

**ТӨРӨӨС ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТАЛААР
БАРИМТЛАХ БОДЛОГО
/2019-2026/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

1.1 Бодлого боловсруулах үндэслэл шаардлага

1274 оноос уламжлагдан ирсэн “Монголын газрын гар зураг” нэр томъёо нь эх дэлхийгээ судлах, зураглах асуудлыг онцгойлон анхаарч, гурван тивийг анх удаа зурагласан өвөг дээдсийн агуу түүхийн тод жишээ билээ.

Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн монгол зургийн уламжлалт энэ аргаар аймаг, хошууд, шавиуд, хилийн харуулуудын газрын зургийг муутуу цаасан дээр хийж байсан нь өдгөө Монгол, Герман, Япон, Польш улсуудын номын сан, архивт хадгалагдаж байдаг.

Өнөөдөр геодези, зураг зүйн салбар нь улсын хилийг тодотгон тогтоох, шалгаж баталгаажуулах, нутаг дэвсгэрийн хэмжээг болон түүн дээрх бүхий л объектуудыг газрын гадаргын нөхцөл байдалд нь геодезийн өндөр нарийвчлал бүхий хэмжил зүйгээр орон зайн харилцан байршлаар зураглаж, байрлалд суурилсан орон зайн болон байрзүй, газрын зургийн тоон мэдээллээр байгаль орчин, хөдөө аж ахуй, хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай зэрэг нийгэм эдийн засгийн бүхий л салбаруудыг хангадаг, батлан хамгаалах аюулгүй байдалд голлох үүрэгтэй улс орны хөгжлийн суурь салбар юм.

Далайд гарцгүй манай орны хувьд батлан хамгаалахын зориулалтаар хөрш орны байгуулсан геодезийн тогтолцоог шинэчлэх, тус ажлыг эрчимжүүлэх асуудал тулгараад байна. НҮБ-ын гишүүн орнуудад хилийн зурвасаа шинэчлэн тогтоох асуудлыг олон улсын геодезийн /ITRF/ тогтолцоонд хийж эхлээд байна.

НҮБ нь уур амьсгал, байгаль дэлхийн өөрчлөлт, байгалийн нууцыг хамтран судалж, байгалийн гэнэтийн гамшиг, бэрхшээлийг хамтдаа даван туулахад дэлхийн улс орнуудыг нэгдэхийг уриалж Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийг гаргасан. Үүнтэй холбоотойгоор өндөр нарийвчлалтай Дэлхийн Геодезийн тулгуур сүлжээ байгуулах асуудал улс орнуудын гол зорилт болоод байна.

Үүнээс үзэхэд геодези, зураг зүйн салбар нь цаашдаа даяаршилд чиглэсэн, дэлхийн навигацийн хиймэл дагуулын системд тулгуурласан GNSS-ийн байнгын ажиглалтын газрын станцууд бүхий геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг бий болгох, ингэхдээ улс орнууд мэдлэг, туршлага, технологи солилцоход чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг дэмжин хөгжих хандлагатай болж байна.

Хиймэл дагуулын технологи өндөр хөгжсөн өнөө үед олон улсын геодезийн хөгжлийн дээрх чиг хандлагад нийцүүлэн үндэсний геодези, зураг зүйн салбарыг өөрийн орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, хил хязгаарын бүрэн бүтэн байдлыг хадгалж, хянахад геодезийн хэмжилт, зураглалын мэдээллийг ашиглах, хэрэглэх өндөр чадамжийг бий болгох чиглэлээр төрийн бодлогыг хөгжүүлэх шаардлага тавигдаж байна.

Геодези, зураг зүйн салбарт баримтлах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, геодезийн салбарт тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хүний нөөц, техник технологи, санхүүгийн чадавхийг бэхжүүлж олон улсын түвшинд нийцүүлэн хөгжүүлэхэд энэхүү бодлогын ач холбогдол чиглэнэ.

Төрөөс геодези зураг зүйн талаар баримтлах бодлогыг салбар эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллагууд, нийт мэргэшсэн боловсон хүчин хамтран Олон улсын байгууллагын дээд хэмжээний уулзалтаас гаргасан уриалга, тунхаглал, Мянганы хөгжлийн зорилт, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, салбар хоорондын бодлогын зорилтуудтай уялдуулан боловсрууллаа.

Монгол улсын Геодези, зураг зүйн салбарын талаар төрөөс баримтлах бодлого нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, салбар хоорондын хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг дунд хугацаанд тодорхойлсон баримт бичиг болно.

Энэхүү баримт бичиг нь салбарын хөгжлийн суурь баримт бичиг учраас 5-10 жил тутамд хэлэлцэн, тухайн үеийн ба ирээдүйн чиг хандлагатай уялдуулан шинэчилж байх шаардлагатай юм.

1.2. Геодези, зураг зүйн салбарын шинжилгээ

Төрөөс геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд салбарын үйл ажиллагаанд хийсэн дараах шинжилгээнд тулгуурлаж байна:

1.2.1. Давуу тал

1.2.1.1. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа бүхэлдээ тоон технологид шилжсэн.

1.2.1.2. Олон улсын харилцаа сайтай.

1.2.1.3. Байрлалын мэдээллийг олон улсын байрлал тодорхойлох GPS, GLONASS, Galileo, BeoDou зэрэг хиймэл дагуулын системээс бодит агшинд тодорхойлох техник, технологийн боломжтой болсон.

1.2.1.4. Геодезийн суурь мэдээллийн нэгдсэн нэг стандарт бүхий өгөгдлийн санг бүрдүүлсэн. Энэхүү өгөгдлийн санд дор дурьдсан мэдээллүүд тоон хэлбэрээр хадгалагдаж, төрийн болон албаны нууцад хамаарахгүй мэдээлэл нь геопорталаар хэрэглэгчдэд хүргэх, онлайн-аар лавлагаа олгох боломжтой болсон. Үүнд:

- Геодезийн байнгын цэг тэмдэгтийн /байрлалын сүлжээний, өндрийн I, II ангийн сүлжээний, гравиметрийн 1,2 дугаар ангийн сүлжээний/ мэдээлэл,
- GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын мэдээлэл,
- Агаар, сансрын зураг, ортофото зураг, өндрийн тоон загвар,
- Нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100 000-ны масштабтай байр зүйн тоон зураг,
- Нутаг дэвсгэрийн 45%-ийг бүрхсэн 1:25 000-ны масштабтай байр зүйн тоон зураг,
- Монгол улсын нийслэл, 21 аймаг, 330 сум, 42 суурингийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг,
- Монгол улсын нийслэл, 21 аймгийн төвийн газар дээрх болон доорх шугам сүлжээний зураглалын тоон мэдээлэл,
- Монгол улсын хот, тосгон болон томоохон суурингаас бусад нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100 000-ны масштабтай, нийслэл, 21 аймаг, 330 сум, 42 суурингийн 1:1000-ны масштабтай объектийн хаягийн тоон зургийн мэдээллийн сан,
- Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тодруулан тогтоосон газар зүйн нэрийн мэдээлэл.

1.2.2. Сул тал

1.2.2.1. Геодезийн суурь мэдээллийн өгөгдлийн нэгдсэн санг бусад төрийн захиргааны байгууллагатай солилцох зөөлөн болон хатуу дэд бүтцийн техник, технологи, тоног төхөөрөмжийн хангамж муу.

1.2.2.2. Геодези, зураг зүйн чиглэлээр эрдэм, шинжилгээ судалгааны ажил хийх дагнасан байгууллага байхгүй, ШУА-д газар зүйн болон информатикийн хүрээлэнгүүд байгаа боловч уялдаа байхгүй.

1.2.2.3. Геодези, зураг зүйн чиглэлээр их дээд сургуульд багшлах боловсон хүчин хомс, эрдэмтэн доктор цөөн.

1.2.2.4. Дотоодын зах зээл бага, ядуурал их байгаагийн улмаас тоон технологиор бий болсон геодези, зураг зүйн бүтээгдэхүүний хэрэглээ 18 дугаар зууны үеийнхээр буюу цаасан технологиор байна.

1.3. Бодлогын хамрах хүрээ

Геодези, зураг зүйн салбар нь улсын хилийг тодотгон тогтоох, шалгаж баталгаажуулах, нутаг дэвсгэрийн хэмжээг болон түүн дээрх бүхий л объектуудыг газрын гадаргын нөхцөл байдалд нь геодезийн өндөр нарийвчлал бүхий хэмжил зүйгээр орон зайн харилцан байршлаар зураглаж, байрлалд суурилсан орон зайн болон байрзүй, газрын зургийн тоон мэдээллээр байгаль орчин, хөдөө аж ахуй, хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай зэрэг нийгэм эдийн засгийн бүхий л салбаруудыг хангадаг, батлан хамгаалах аюулгүй байдалд голлох үүрэгтэй улс орны хөгжлийн суурь салбар учраас Төрөөс гердези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх бөгөөд хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 1.3.1. бүх шатны төрийн байгууллага,
- 1.3.2. төрийн өмчит болон төрийн өмчит оролцоотой хуулийн этгээд,
- 1.3.3. хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага,
- 1.3.4. иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага,
- 1.3.5. иргэд

1.4. Төрөөс баримтлах бодлогын зарчим

1.4.1. Монгол Улсын Үндэсний язгуур эрх ашигт нийцэх.

1.4.2. Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, түүнд заасан тэргүүлэх чиглэлийн хүрээнд зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, тодорхой хугацаатай, хүрэх үр дүн нь хэмжигдэхүйц байх.

1.4.3. Монгол Улсын хууль болон Олон улсын гэрээнд нийцсэн байх.

1.4.4. Олон улсын болон үндэсний стандартад нийцэх.

1.4.5. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, ногоон дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр инновацийн үйл ажиллагааг дэмжих.

1.4.6. Төр, шинжлэх ухаан, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах.

1.4.7. Геодези, зураг зүйн салбарт оролцогч талуудын үйл ажиллагаанд ил тод, шударга өрсөлдөөн, хариуцлагатай, тэгш байдлыг хангах.

1.4.8. Геодези, зураг зүйн салбарын бүтээгдэхүүн нь нийгэм эдийн засгийн бүх салбар, бүс нутаг, иргэн бүрт хүртээмжтэй байх.

1.4.9. Олон улс болон бүс нутгийн хамтын ажиллагаанд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих.

1.4.10. Бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх

1.4.11. Шинэ технологи, тоног төхөөрөмж, програм хангамжийг Монгол Улсад нутагшуулахдаа бүхэлдээ гадаадын аль нэг улс, иргэн, аж ахуй нэгжээс хамааралгүй байлгах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Алсын хараа

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд олон улсын стандартад нийцсэн геодези, зураг зүйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүтээгдэхүүнээрээ батлан хамгаалах, дэд бүтэц, нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчин, боловсрол, олон нийтийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангах салбар болгон хөгжүүлэх.

2.2. Зорилго

Монгол улсын нийгэм эдийн засгийн бүхий л салбарыг олон улсын стандартад нийцсэн геодези, зураг зүйн бүтээгдэхүүнээр хангахад бодлогын зорилго оршино.

2.3. Зорилт

Бодлогын зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.3.1. Нийгэм эдийн засгийн өөрчлөлт, олон улсын болон үндэсний хөгжлийн чиг хандлага, бодлоготой уялдуулан геодези, зураг зүйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

2.3.2. Дэлхийн хэлбэр хэмжээ, түүний гадаад таталцлын орон, туйлын хөдөлгөөнийг судлах, өөрийн орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлох, тусгаг сонгох, геодезийн солбицол, өндрийн тогтолцоог тогтоох, газрын царцдасын хэвтээ ба босоо хөдөлгөөнийг өндөр нарийвчлалын геодезийн хэмжлээр судлах зэрэг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэн хөгжүүлэх, түүний үр дүнгээр геодези, зураг зүйн үйлдвэрлэл явуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.

2.3.3. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, салбарын хөгжлийн шаардлагыг хангасан мэдлэг, чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бий болгоно.

2.3.4. Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж тэдгээрийн тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгоно.

2.3.5. Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэх, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.

2.3.6. Хот байгуулалт, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, өргөтгөх, ашиглах үед хийгдэх инженер геодезийн хэмжлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

2.3.7. Алсын хараа, эрхэм зорилгодоо амжилттай хүрэхэд салбарын ажиллах хүч, цаг хугацаа, хөрөнгө санхүү, тоног төхөөрөмж, түүхий эд, материалын нөөцийг үр ашигтайгаар чиглүүлэн зохицуулах, үүний тулд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, их дээд сургуулийн хөдөлмөрийн хуваарь, гүйцэтгэх болон менежментийн чиг үүргийг нарийвчлан, оновчтойгоор төрөлжүүлж, чадварлаг арга барил бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлнэ.

2.3.8. Геодези, зураг зүйн салбарын төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримтыг цахимжуулж дуусгах, архивын цахим мэдээллийн сан бүрдүүлэн, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, ил тод, хүртээмжтэй цахим үйлчилгээг нэвтрүүлж, төрийн архивийн үйл ажиллагааг олон улсын төвшинд хүргэж сайжруулан хөгжүүлнэ.

2.3.9. Геодезийн хэмжил зүйн багаж баталгаажуулалтын лабораторийг олон улсын стандартад нийцсэн төвшинд хүргэж сайжруулан чадавхижуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Бодлогыг хэрэгжүүлэх арга зам нь дунд хугацааны стратеги, үндэсний болон дэд хөтөлбөрөөр тодорхойлогдох бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

3.2. Бодлогыг дор дурьдсан 2 үе шатаар хэрэгжүүлэх бөгөөд үндсэн стратеги, шат дараалал нь дараах байдалтай байна.

I үе шат /2019-2022 он/: Эхний үе шатанд нийгэм эдийн засгийн өөрчлөлт, олон улсын болон үндэсний хөгжлийн чиг хандлага, бодлоготой уялдсан эрх зүйн орчинд, шинжлэх ухааны судалгаа шинжилгээний үр дүнд үндэслэсэн геодези зураг зүйн үйл ажиллагааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг, чадвар, туршлага бүхий хүний нөөцөөр гүйцэтгэж, олон улсын стандартад нийцсэн бодит агшины өгөгдөл, мэдээлэл болон бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг шуурхай хангах нөхцөл бүрдсэн байна.

II үе шат /2023-2026 он/: Дараагийн үе шатанд Үндэсний геодезийн эрдэм шинжилгээний судалгааны төвд хийсэн туршилт судалгаагаар гаргаж авсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоид бүхий солбицлын тогтолцоонд геодези, зураг зүйн үйл ажиллагааг явуулдаг, газрын станцаар хиймэл дагуулаас мэдээ хүлээн авч, боловсруулан хэрэглэгчдэд дамжуулдаг, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт геодези, зураг зүйн бүтээгдэхүүний онлайн үйлчилгээг үзүүлдэг, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн салбар болон хөгжсөн байна.

3.3. Нийгэм эдийн засгийн өөрчлөлт, олон улсын болон үндэсний хөгжлийн чиг хандлага, бодлоготой уялдуулан геодези, зураг зүйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд **геодези, зураг зүйн салбарын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр** хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1. Геодези, зураг зүйн салбарын хөгжлийг хангахад шаардлагатай олон улсын геодези, зураг зүйн конвенцэд нэгдэнэ.

3.3.2. Монгол улсын “Геодези, зураг зүйн тухай” хуулийг боловсронгуй болгож, шинэчлэн батлуулна. Хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана.

3.3.3. Улс орны аюулгүй байдлыг хангах чиглэлээр геодези, зураг зүйн үйл ажиллагааны хөтөлбөртэй байна.

3.3.4. Улс орны хэмжээнд Газар зүйн нэрийн асуудал хариуцсан Үндэсний зөвлөл байгуулна.

3.3.5. Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах санг бий болгож, түүнийг бүрдүүлэх эх үүсвэр, зарцуулах журмыг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангана.

3.3.6. Геодези, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөгдөж байгаа стандарт, журам, дүрэм, зааврыг орчин үеийн техник технологи, олон улсын заавар, стандартад нийцүүлэн иж бүрнээр шинэчлэн боловсруулж, улс орныг зурагжуулах үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

3.3.7. Салбарын ажлын норм, үнэлгээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор бусад салбарт мөрдөгдөж байгаа адил агуулга бүхий норматив тогтоосон баримт бичгүүдийг уялдуулан нэгдсэн тогтолцоонд оруулна.

3.3.8. Геодези, зураг зүйн ажилд магадлал хийх, үйлдвэрлэл үйлчилгээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгоно.

3.3.9. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төрийн хяналтын тогтолцоог төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр боловсронгуй болгоно.

3.3.10. Геодези зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг иргэдэд ойртуулах харилцааг зохицуулах, орон нутгийн бүтцийг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, чадавхижуулна.

3.4. Дэлхийн хэлбэр хэмжээ, түүний гадаад таталцлын орон, туйлын хөдөлгөөнийг судлах, өөрийн орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлох, тусгаг сонгох, геодезийн солбицол, өндрийн тогтолцоог тогтоох, газрын царцдасын хэвтээ ба босоо хөдөлгөөнийг өндөр нарийвчлалын геодезийн хэмжлээр судлах зэрэг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэн хөгжүүлэх, түүний үр дүнгээр геодези, зураг зүйн үйлдвэрлэл явуулдаг тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд **геодези, зураг зүйн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээг хөгжүүлэх чиглэлээр** хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.1. Дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх чиглэлээр туршилт судалгаа, хийх, үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, норм норматив боловсруулахад чиглэсэн шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийж хэрэгжүүлдэг эрдэм шинжилгээ, туршилт судалгааны төв байгуулна.

3.4.2. Хиймэл дагуулаас мэдээ, мэдээлэл хүлээн авч дамжуулах газрын станц, сансрын зураг боловсруулах лабораторитой болох асуудлаар төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллана.

3.4.3. Математик зураг зүйн чиглэлээр судалгаа явуулж, Монгол улсад мөрдөж буй тусгагийн зайн, өнцгийн гажилтыг тооцоолох судалгаа хийх, засварын коэффициентүүдийг нийтэд зарлана.

3.4.4. Ази, Номхон далайн бүсийн сүлжээнд холбогдсон 6-7 байнгын ажиллагаатай станцын давтан хэмжилтийг жил бүр тогтмол хийж хэвшүүлэх, тухайн

хэмжилтийн үр дүнгээр эх газрын хавтангийн шилжилтийг судалгааны аргаар тодорхойлж байна.

3.4.5. Геодези, зураг зүйн суурь судалгаа, шинжилгээний ажлыг магистр, докторын судалгааны ажлаар хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлнэ.

3.4.6. Монгол орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлж дэлхийн ерөнхий эллипсоид хоорондын хөрвүүлэлтийн параметрийг гаргаж хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.4.7. Монгол улсын газрын гадаргын шилжилтийг тооцоолж, зураглал хийгдсэн эрин хоорондын хөрвүүлэлтийн параметрийг динамикаар тооцох онлайн үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.5. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, салбарын хөгжлийн шаардлагыг хангасан мэдлэг, чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бий болгох зорилтын хүрээнд **геодези, зураг зүйн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр** хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.5.1. Их, дээд сургуульд геодези, зураг зүйн чиглэлээр багшлах боловсон хүчний 30%-ийг өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх болон магистр, докторын зэрэг хамгаалах сургалтанд хамруулах, төрийн зардлаар суралцуулах асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

3.5.2. Гадаад орнуудад жилд геодези, зураг зүйн 5 бакалавр, 2 магистр, 1 доктор оюутныг төрийн зардлаар суралцуулна.

3.6. Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж тэдгээрийн тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд **Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэх чиглэлээр** хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.6.1. Геодезийн сүлжээний үндэсний эхлэл цэг байгуулж, олон улсын байрлал, өндөр, гравиметрийн сүлжээтэй холбох, эхлэл утгуудыг тодорхойлж Улсын геодезийн сүлжээг холбон солбицол өндрийн нэгдсэн тогтолцоонд оруулна.

3.6.2. Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах байнгын ажиллагаатай 68 станцыг олон улсын В ангиллын сүлжээний нарийвчлалыг хангах түвшинд байгуулж хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.6.3. Хот суурин газрын байрлалын С ангиллын сүлжээг байнгын ажиллагаатай станцтай холбон, норматив баримт бичигт заасан нарийвчлалыг хангаж сайжруулна.

3.6.4. Өндрийн 2-р ангийн сүлжээний давтан хэмжилт хийнэ.

3.6.5. Гравиметрийн тулгуур сүлжээг шинэчлэн сайжруулна.

3.6.6. Монгол улс - БНХАУ-ын хилийн дагуу гравиметрийн хэмжилт, боловсруулалт хийх.

3.6.7. Геоидын өндрийн загварын нарийвчлалыг сайжруулна.

3.7. Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэх, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангах зорилтын хүрээнд **Байр зүйн болон сэдэвчилсэн зургийн өгөгдөл мэдээлэл, бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр** хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.7.1. Монгол Улсын аймаг, сум, суурин газрын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн болон газар доорх, дээрх шугам сүлжээний тоон зургийн мэдээллийн санг үүсгэж, нэмэлт өөрчлөлтийг тухай бүр оруулж, шинэчлэлтийг 2 жил тутамд хийж, хэрэглэгчдэд түгээх тогтолцоог бий болгоно.

3.7.2. Монгол орны нийт нутаг дэвсгэрийг 1:25000-ны масштабын байр зүйн зургаар зураглаж, нэмэлт өөрчлөлтийг тухай бүр хийж хэрэглэгчдэд түгээх тогтолцоог бүрдүүлнэ.

3.7.3. 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг хиймэл дагуулын мэдээгээр тодруулж, шинэчлэн, геодези, байр зүйн нэгдсэн сангийн мэдээллийг баяжуулна.

3.7.4. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийж, мэдээллийн сан үүсгэн онлайн үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.7.5. Газрын зургийн талаарх мэдлэгийг боловсролын салбарын бүх шатанд сургалтын хөтөлбөр, сурах бичгээр дамжуулан олгох тогтолцоотой болгоно.

3.7.6. Газрын зургийн суурь агуулгыг масштаб тус бүрээр тодорхойлж нэг маягийн суурь бүхий сургалтын газрын зураг, атласын агуулгыг сургалтын хөтөлбөртэй уялдуулан зохиож шинэчлэх, хэрэглээнд хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.7.7. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондох хилийн цэсийг шалгаж, баталгаажуулах ажлыг холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.7.8. Орчин үеийн хэвлэлийн технологийг зураг зүйн үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

3.7.9. Геодези, байр зүйн зургийн мэдээллийн системийг байгуулж байр зүйн тоон зургийн мэдээллийг хэрэглэгчдэд орон зайн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүргэнэ.

3.8. Хот байгуулалт, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, өргөтгөх, ашиглах үед хийгдэх геодезийн хэмжлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд **Инженер геодезийн норм, нормативийг боловсронгуй болгон бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.8.1. Хот тосгон бусад суурины газрын болон инженерийн шугам сүлжээний, бүтээн байгуулалтын үед хийгддэг инженер геодезийн хэмжилтүүд, газар доорх шугам сүлжээний зураглалыг гурван хэмжээст байдалд гүйцэтгэж 1:100 хүртэлх том масштабын зураглалын мэдээллээр олон нийтэд үйлчлэнэ.

3.8.2. Инженер геодезийн мэдээллийн санг аймаг орон нутагт байгуулж, газар, геодезийн мэдээллийн нэгдсэн сантай холбож мэдээллийг саадгүй солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.8.3. Барилга байгууламжийн ашиглалт, насжилтын мониторинг хийхэд геодезийн хэмжилтийн ажлыг гүйцэтгэх шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах ажлыг тогтмолжуулна.

3.9. Алсын хараа, эрхэм зорилгодоо амжилттай хүрэхэд салбарын ажиллах хүч, цаг хугацаа, хөрөнгө санхүү, тоног төхөөрөмж, түүхий эд, материалын нөөцийг үр ашигтайгаар чиглүүлэн зохицуулах, үүний тулд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, их дээд сургуулийн хөдөлмөрийн хуваарь, гүйцэтгэх болон менежментийн чиг үүргийг нарийвчлан, оновчтойгоор төрөлжүүлж, чадварлаг арга барил бүхий удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд **геодези,**

зураг зүйн салбарын удирдлагын тогтолцоо, бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгон хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.9.1. Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, энэхүү чиглэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиуд, тэдгээрийн нэгж хэсгүүдийн (салбарын үйл ажиллагаатай холбоо бүхий) үйл ажиллагаа нягт уялдсан, чанарын хяналтын босоо тогтолцоо бүхий удирдлага, зохион байгуулалтын бүтцийг бий болгож, жигдрүүлэх.

3.9.2. Эрхэлсэн сайдын дэргэд геодези, зураг зүйн чиглэлийн шинжлэх ухаан, технологийн орон тооны бус зөвлөлийг бий болгож салбарын норм, нормативийн баримт бичиг, дүрэм, журмыг хэлэлцэн шийдвэрлэдэг тогтолцоог бүрдүүлнэ.

3.10. Геодези, зураг зүйн бүтээгдэхүүний төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримтыг тоон хэлбэрт оруулан, цахим мэдээллийн сан бүрдүүлэн, цахим үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд **төрийн архивийн үйл ажиллагааг олон улсын төвшинд хүргэж сайжруулан хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.10.1. Геодези, зураг зүйн салбарын төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримтыг цахимжуулж дуусгана.

3.10.2. Салбарын архивын сан хөмрөгийг байнга баяжуулж, үйл ажиллагааны болон эрдэм шинжилгээ, судалгааны баримтаар нөхөн бүрдүүлэлт хийнэ.

3.10.3. Салбарын архивын нэгдсэн цахим мэдээллийн сан бүрдүүлж, хэрэглэгчид хүссэн мэдээллээ хүссэн газраасаа хүссэн цагтаа авч ашиглах боломжийг буй болгон цахим үйлчилгээ нэвтрүүлнэ.

3.10.4. Геодези, зураг зүйн салбарын төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй түүх, соёлын үнэт баримтыг Монгол улсын хосгүй үнэт өвд бүртгүүлнэ.

3.10.5. Салбарын үйл ажиллагааг сурталчлах, танин мэдэхүйг хөгжүүлэх үүднээс геодези зураг зүйн түүхэн хөгжил үйл ажиллагааг харуулсан үзэсгэлэн музей байгуулах, салбарын номын санг өргөтгөн баяжуулж олон нийтийн хүртээл болгоно.

3.10.6. Төрийн архивын баримтыг хадгалалт, хамгаалалт, ашиглалтын стандарт орчныг бүрдүүлэх зорилгоор төрийн архивын зориулалтын байр бариулна.

3.10.7. Улсын төсвийн болон төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэх ижил төстэй ажлын давхардлыг арилгах, мэдээллийн ил тод хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор төрийн байгууллагуудын архив хоорондын цахим мэдээлэл солилцох систем нэвтрүүлнэ.

3.11. Геодезийн хэмжил зүйн багаж баталгаажуулалтын лабораторийг олон улсын стандартад нийцсэн төвшинд хүргэж сайжруулан чадавхижуулах зорилтын хүрээнд **геодезийн хэмжил зүйн багаж баталгаажуулалтын лабораторийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

3.11.1. Геодезийн үйлдвэрлэлд шинээр нэвтэрч буй геодезийн хэмжлийн багаж хэрэгслийг шалгах, баталгаажуулахад шаардагдах техник технологи, програм хангамжийн судалгааг тухай бүр хийж, худалдан авдаг үйл ажиллагааг тогтмолжуулна.

3.11.2. Геодезийн хэмжлийн багаж хэрэгслийг шалгах, тохируулах, баталгаажуулах заавар, үндэсний стандарт боловсруулах, олон улсын стандартыг орчуулан үндэсний стандартаар батлуулж үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

3.11.3. Лабораторид ажиллах боловсон хүчний тоог нэмэгдүүлэн чадавхийг дээшлүүлж олон улсын төвшинд сургаж мэргэшүүлнэ.

3.11.4. Геодезийн хэмжил зүйн багаж баталгаажуулалтын лабораторийг олон улсын стандартыг хангасан шалгалт баталгаажуулалтын эталон тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглоно.

3.11.5. Зай хэмжилтийн, агаарын зураглалын, гравиметрийн шалгалт тохируулгын жишилтийн полигонуудыг өнцөг, өндрийн хэмжилтийн, агаар мандлаас

газрын зураг авдаг бүх төрлийн камерийн, хүндийн хүчний утгын жишилт гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэн өргөтгөн сайжруулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

5.1. Төрөөс геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгана.

5.2. Төрөөс геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Үүнд:

- 5.2.1. Улсын болон орон нутгийн төсөв
- 5.2.2. Дотоод гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж
- 5.2.3. Улсын их хурлаас хуульчлан баталсан эх үүсвэр
- 5.2.4. Бусад

ТАВДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

6.1. Геодези, зураг зүйн бүхий л мэдээллүүдийг агуулсан мэдээллийн нэгдсэн сан бүхий цахим системийг байгуулж, давхардалгүй мэдээллээр батлан хамгаалах, дэд бүтэц, нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчны хэрэгцээ шаардлагыг бүрэн хангадаг болгоно.

6.2. Бодлогын хэрэгжилтийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээнд удирдан, бусад яам, агентлаг, их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд, төрийн бус байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаагаар зохион байгуулна.

6.3. Бодлогын гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч байгууллагууд геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлан мэдээллийг шалгуур үзүүлэлт тус бүрээр заасан хугацаанд хүргүүлнэ.

6.4. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, 4 жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэж ажлыг зохион байгуулж тайланг Засгийн газарт танилцуулна.

6.5. Бодлогын хяналт шинжилгээ нь мэдлэгт суурилсан, хэрэглэгч өөрөө хянадаг байх нөхцлийг хангасан байна.

6.6. Бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайлан мэдээллийг олон нийтэд мэдээлж сурталчилна.

**ТӨРӨӨС ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН**

| Д/ Д | ЗОРИЛТ | ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | ХЭМ- ЖИХ НЭГЖ | ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ | ҮЗҮҮЛЭЛТ | | | МЭДЭЭЛ- ЛИЙН ЭХ СУРВАЛЖ | ХЭРЭГ- ЖҮҮЛЭХ БАЙГУУЛ- ЛАГУУД |
|---------|---|---|---------------------|--|--|---|---|---------------------------------------|--|
| | | | | | СУУРЬ ТҮВШИН | ЗОРИЛТОТ ТҮВШИН 2022 | ЗОРИЛТОТ ТҮВШИН 2026 | | |
| 1. | Нийгэм эдийн засгийн өөрчлөлт, олон улсын болон үндэсний хөгжлийн чиг хандлага, бодлоготой уялдуулан геодези, зураг зүйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | 3.3.1. Геодези, зураг зүйн салбарын хөгжлийг хангахад шаардлагатай олон улсын геодези, зураг зүйн конвенцэд нэгдсэн байна | Кон- венц | Олон улсын харилцаанд тавигддаг шаардлагад нийцсэн байх | НҮБ-ын Геоорон зайн мэдээллийн менежментийн Ази-Номхон далайн бүсийн хороо /ГОЗММАНДБХ/-ны гүйцэтгэх зөвлөлийн гишүүн байгууллагаар ажиллаж байна. | Олон улсын геодезийн холбоо (ОУГХ) / International Association of Geodesy / -ны гишүүн болсон байна | Олон улсын Дэлхийн эргэлт болон тулгуур сүлжээний үйлчилгээ (ОУДЭТСҮ) / International Earth Rotation and Reference Systems Service / -нд нэгдсэн байна | НҮБ-ын ГОЗМАНД БХ болон ОУГХ, ОУДЭТСҮ | БХБЯ, ГЗБГЗЗГ |
| | | 3.3.2. Монгол улсын "Геодези, зураг зүйн тухай" хуулийг боловсронгуй болгож, шинэчилэн батлуулна. Хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана. | хууль | Монгол улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд нийцсэн байна. | Геодези, зураг зүйн тухай" хууль 1997 онд батлагдсанаас хойш бусад хууль шинэчлэн батлагдсан, эсвэл нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой 16 зүйл, 41 хэсэг, заалтад өөрчлөлт орж, 2 хэсэг шинээр нэмэгдсэн. Ингэснээр 123 заалтын 30 хувьд өөрчлөлт орж салбарын харилцааг зохицуулж буй зарим зүйл, заалтын уялдаа алдагдахад хүрсэн. | Монгол улсын "Геодези, зураг зүйн тухай" хуулийн шинэчилсэн найруулга батлагдан, мөрдөгдөж эхэлсэн байна. | Монгол улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дагуу "Геодези, зураг зүйн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтэд үнэлгээ хийгдэж хэрэгжилтийн явцад гарсан хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлсэн, цаашид | БХБЯ, ГЗБГЗЗГ | ХЗДХЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ |

| | | | | | | | | |
|--|----------|--|--|---|--|---|--------------------------|--|
| | | | | | | хуулийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээг авсан байна. | | |
| 3.3.3. Улс орны аюулгүй байдлыг хангах чиглэлээр геодези, зураг зүйн үйл ажиллагааны хөтөлбөртэй байна. | хөтөлбөр | Монгол улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолд нийцсэн байна. | байхгүй | Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дэд хөтөлбөрүүд боловсруулагдан батлагдсан байна | Геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийгдэж, үнэлгээний дагуу арга хэмжээ авагдсан байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ХЗДХЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ | |
| 3.3.4. Улс орны хэмжээнд газар зүйн нэрийн асуудал хариуцсан Үндэсний зөвлөл байгуулна. | Зөвлөл | Газар зүйн нэрийн асуудлыг олон улсын баримт бичиг, монгол улсын хууль, тогтоомжид нийцүүлэн эрхэлнэ. | байхгүй | Газар зүйн нэрийн үндэсний зөвлөл Монгол Улсын засгийн газрын дэргэд байгуулагдсан байна. | Газар зүйн нэрийн үндэсний зөвлөл нь Аймаг, нийслэл бүрт салбар зөвлөлтэй болсон байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ЗГ БХБЯ, ГЗБГЗЗГ | |
| 3.3.5. Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах санг бий болгож, түүнийг бүрдүүлэх эх үүсвэр, зарцуулах журмыг боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангана. | сан | байна | байхгүй | Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах санг бүрдүүлэх зарцуулах журам батлагдан хэрэгжиж эхэлсэн байна. | Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах сангийн үйл ажиллагаа жигдэрсэн байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | СЯ, ХЗДХЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ | |
| 3.3.6. Геодези, зураг зүйн үйлдвэрлэлд мөрдөгдөж байгаа | | | Салбарын хэмжээнд 2016 оны байдлаар БХБ-ын Сайдын баталсан 32 норм | | | | | |

| | | | | | | | | |
|--|---|------|---------------------------------|--|---|--|---------------|-----------------------------------|
| | стандарт, журам, дүрэм, зааврыг орчин үеийн техник технологи, олон улсын заавар, стандартад нийцүүлэн иж бүрнээр шинэчлэн боловсруулж, улс орныг зурагжуулах үйл ажиллагаанд мөрдлөг болгоно. | хувь | Хууль, тогтоомжид нийцсэн байна | дүрэм, агентлагийн даргын баталсан 31 журам, заавар мөрдөгдөж байна. Шинээр боловсруулах шаардлага-тай 17 норм дүрэм, 9 стандарт, шинэчлэх шаардлагатай 14 норм дүрэм байна. Үүнээс 2016-2018 онд шинээр 2 стандарт, 4 норм дүрэм, 1 зааврыг дүрэм болгож, 2 зааврыг стандарт болгож, 3 норм дүрэмд өөрчлөлт оруулан батлуул-сан ¹ . Ингэснээр нийт норм дүрэм, стандартын 10%-ийг шинэчил-сэн байна. | 50%-ийг шинэчлэн боловсруулж, улс орныг зурагжуулах үйл ажиллагаанд мөрдлөг болгосон байна. | 100% буюу бүгдийг нь шинэчилж улс орныг зурагжуулах үйл ажиллагаанд мөрдлөг болгосон байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ХЗДХЯ, БХБЯ, СХЗГ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| | 3.3.7. Салбарын ажлын норм, үнэлгээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор бусад салбарт мөрдөгдөж байгаа адил агуулга бүхий норматив тогтоосон баримт бичгүүдийг уялдуулан нэгдсэн тогтолцоонд оруулна. | хувь | Хууль, тогтоомжид нийцсэн байна | Авто зам, барилга, хот төлөвлөлт, улсын бүртгэл, оюуны өмч, иргэний нисэх зэрэг салбарт мөрдөгдөж буй баримт бичигт нийцүүлэн геодези зураг зүйн салбарын норм, үнэлгээг шинэчилнэ. | Бусад салбарт мөрдөгдөж буй баримт бичигт геодези, зураг зүйн ажил үйлчилгээ тусгагдаж нэгдсэн тогтолцоонд шилжих эхлэл тавигдаж, хэрэгжиж эхэлсэн байна. | Бусад салбар хэрэгждэг геодези зура зүйн үйл ажиллагаа жигдэрч, харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд хүрсэн байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ХЗДХЯ, БХБЯ, СХЗГ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| | 3.3.8. Геодези, зураг зүйн ажилд магадлал хийх, үйлдвэрлэл үйлчилгээнд зөвлөх үйлчилгээ | хувь | | байхгүй | Геодези, зураг зүйн ажилд магадлал хийх, үйлдвэрлэл үйлчилгээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх журам, дүрэм, эрх | Нийт ажлын 80%-д магадлал хийдэг болсон байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ХЗДХЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |

| | | | | | | | | | |
|----|-------------------------------|--|----------------|---------------------------------|---|--|---|---------------|---------------------------------|
| | | үзүүлэх тогтолцоог бий болгоно. | | Хууль, тогтоомжид нийцсэн байна | | зүйн баримт бичгийг боловсруулан баталгаажуулж, нийт ажлын 40%-д магадлал хийдэг болсон байна. | | | |
| | | 3.3.9. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төрийн хяналтын тогтолцоог төр-хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр боловсронгуй болгоно. | Чиг үүрэг | Хууль, тогтоомжид нийцсэн байна | байхгүй | Засгийн газар, эрхэлсэн сайдын холбогдох шийдвэрийг гаргуулах ажлыг зохион байгуулж 2 чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлдэг болсон байна. | 5 чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлдэг болсон байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ХЗДХЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| | | 3.3.10. Геодези зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг иргэдэд ойртуулах, харилцааг зохицуулах, орон нутгийн бүтцийг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, чадавхижуулна. | Боловсон хүчин | Хууль, тогтоомжид нийцсэн байна | Өнөөдрийн байдлаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус бүр 1, нийслэлийн Газрын албанд 3, нийтдээ 24 геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн хөдөө, орон нутагт ажиллаж байна. | Нийслэлийн Газрын албанд геодези, зураг зүйн асуудал хариуцсан 5-6 (3+2 ба 3) мэргэжилтэнтэй нэгж ажиллах бөгөөд ингэснээр хөдөө орон нутагт ажилладаг мэргэжилтэй боловсон хүчний тоо 26-27 болсон байна. | Дүүргийн газрын алба болон томоохон 5 сумдад тус бүр 1 геодези, зураг зүйн асуудал хариуцсан (9+5) мэргэжилтэнтэй болсон байна. Ингэснээр хөдөө орон нутагт ажилладаг мэргэжилтэй боловсон хүчний тоо 40-41 болсон байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | ЗГХЭГ, СЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| 2. | Дэлхийн хэлбэр хэмжээ, түүний | 3.4.1. Дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх | төв | | байхгүй | Гадаад, дотоодын туршлагын талаарх судалгааг хийж, Эрдэм шинжилгээ, | Эрдэм шинжилгээ, туршилт судалгааны төв байгуулагдсан, | БХБЯ, ГЗБГЗЗГ | СЯ, БХБЯ, ШУА, ГЗБГЗЗГ, |

| | | | | | | | | | |
|--|--|--|--------------|--|---------|---|---|---------------|-------------------------------|
| | гадаад таталцлын орон, туйлын хөдөлгөөнийг судлах, өөрийн орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлох, тусгаг сонгох, геодезийн солбицол, өндрийн тогтолцоог тогтоох, газрын царцдасын хэвтээ ба босоо хөдөлгөөнийг өндөр нарийвчлалын геодезийн хэмжлээр судлах зэрэг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэн | чиглэлээр туршилт судалгаа, хийх, үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, норм норматив боловсруулахад чиглэсэн шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийж хэрэгжүүлдэг эрдэм шинжилгээ, туршилт судалгааны төв байгуулна. | | Хууль, тогтоомж, олон улсын стандартад нийцсэн байна | | туршилт судалгааны төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан батлуулж, санхүүжилтийн эх үүсвэрийг олох ажил эхэлсэн байна. | үүгээр дамжуулан гадаад орнуудын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг тогтолцоо бүрдсэн байна. | | ГФЗЗХ |
| | геодезийн солбицол, өндрийн тогтолцоог тогтоох, газрын царцдасын хэвтээ ба босоо хөдөлгөөнийг өндөр нарийвчлалын геодезийн хэмжлээр судлах зэрэг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэн | 3.4.2. Хиймэл дагуулаас мэдээ хүлээн авч боловсруулах лаборатори бүхий дамжуулах газрын суурин станцтай болох асуудлаар төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллана. | станц | Хууль, тогтоомж, олон улсын стандартад нийцсэн байна | байхгүй | Хиймэл дагуулаас мэдээ хүлээн авч боловсруулан, хэрэглэгчдэд дамжуулах газрын суурин станцын техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн байна. | Хиймэл дагуулын газрын суурин станц баригдсан байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | СЯ, БХБЯ, ШУА, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| | гадаад таталцлын орон, туйлын хөдөлгөөнийг судлах, өөрийн орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлох, тусгаг сонгох, геодезийн солбицол, өндрийн тогтолцоог тогтоох, газрын царцдасын хэвтээ ба босоо хөдөлгөөнийг өндөр нарийвчлалын геодезийн хэмжлээр судлах зэрэг шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэн | 3.4.3. Математик зураг зүйн чиглэлээр судалгаа явуулж, Монгол улсад мөрдөж буй тусгагийн өнцөг, зайн гажилтыг тооцоолох судалгаа хийх, засварын | коэфф ициент | Норм, дүрэм, олон улсын стандартад нийцсэн байна | байхгүй | Монгол улсад мөрдөж буй тусгагийн өнцөг, зайн гажилтыг тооцоолох судалгаа хийгдэж, засварын коэффициентүүдийг тодорхойлсон, | Тусгагийн өнцөг, зайн гажилтын засварын коэффициентүүд нийтэд зарлагдан хэрэглээнд нэвтэрсэн байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | СЯ, БХБЯ, ШУА, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |

| | | | | | | | | |
|---|---|------------------------------------|--|--|---|--|---------------------------|-----------------------------------|
| хөгжүүлэх, түүний үр дүнгээр геодези, зураг зүйн үйлдвэрлэл явуулдаг тогтолцоог бүрдүүлэх | коэффициентүүдийг нийтэд зарлана | | | | Засгийн газраар батлуулсан байна | | | |
| | 3.4.4. Ази, Номхон далайн бүсийн сүлжээнд холбогдсон 6-7 байнгын ажиллагаатай станцын давтан хэмжилтийг жил бүр тогтмол хийж хэвшүүлэх, тухайн хэмжилтийн үр дүнгээр эх газрын хавтангийн шилжилтийг судалгааны аргаар тодорхойлж байна | тайлан | Хууль, тогтоомж, норм, дүрэм, олон улсын стандартад нийцсэн байна | Ази, Номхон далайн бүсийн сүлжээний хэмжилтэд 1999 оноос хойш оролцож байна. Ази номхон бүсийн геодезийн группээс хэмжилтийн ажилд оролцсон тохиолдолд тайлан ирүүлдэг боловч түүнийг монгол хэлэнд хөрвүүлэн олны хүртээл болгож байгаагүй зөвхөн дотоод үйл ажиллагаанд ашигладаг. | Давтан хэмжилтийн тайланг жил бүр тогтмол гаргаж, дотоодод төдийгүй олон улсад зарладаг болсон байна. /3 тайлан/ | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. /4 тайлан/ | БХБЯ, ГЗБГЗЗГ | БХБЯ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| | 3.4.5. Геодези, зураг зүйн суурь судалгаа, шинжилгээний ажлыг магистр, докторын судалгааны ажлаар хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлнэ. | журам | Хууль, тогтоомж, норм, дүрэм, олон улсын болон үндэсний стандартад нийцсэн байна | байхгүй | Холбогдох журам, эрх зүйн баримт бичиг боловсруулагдан баталгаажиж, түүний дагуу геодези, зураг зүйн суурь судалгаа, шинжилгээний ажлын сэдвийг холбогдох их дээд сургуулиудад хүргүүлж, магистр, докторын судалгааны ажил хийгддэг болсон байна. /1 журам/ | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | БХБЯ, БСШУСЯ, ШУА, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| 3.4.6. Монгол орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлж | параметр | Хууль, тогтоомж, норм, дүрэм, олон | байхгүй | Монгол орны нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон үндэсний эллипсоидыг тодорхойлох | Үндэсний эллипсоидыг гаргаж авсан, дэлхийн ерөнхий эллипсоид хоорондын | БХБЯ, ГЗБГЗЗГ | БХБЯ, ШУА, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ | |

| | | | | | | | | | |
|----|---|--|--------------|---|---|--|--|---------------|------------------------------|
| | | дэлхийн ерөнхий эллипсоид хоорондын хөрвүүлэлтийн параметрийг гаргаж хэрэглээнд нэвтрүүлнэ. | | улсын стандартад нийцсэн байна | | судалгааг хийж эхлүүлнэ. | хөрвүүлэлтийн параметруудийг тодорхойлсон, Засгийн газраар батлуулан нийтэд зарлаж хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | | |
| | | 3.4.7. Монгол улсын газрын гадаргын шилжилтийг тооцоолж, зураглал хийгдсэн эрин хоорондын хөрвүүлэлтийн параметрийг динамикаар тооцох онлайн үйлчилгээг нэвтрүүлнэ | Баримт бичиг | Хууль, тогтоомж, норм, дүрэм, олон улсын стандартад нийцсэн байна | байхгүй | Холбогдох дүрэм журам, арга зүй, аргачлал, эрх зүйн баримт бичиг, техник, технологийн шийдэл боловсруулагдан баталгаажсан байна. /1 журам, 1 техник, технологийн шийдэл/ | Эрин хоорондын хөрвүүлэлтийн параметрийг динамикаар тооцох онлайн үйлчилгээг нэвтрүүлсэн, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна. | БХБЯ, ГЗБГЗЗГ | БХБЯ, ШУА, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
| 3. | Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, салбарын хөгжлийн шаардлагыг хангасан мэдлэг, чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бий болгох | 3.5.1. Их, дээд сургуульд геодези, зураг зүйн чиглэлээр багшлах боловсон хүчинг өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх болон магистр, докторын зэрэг хамгаалах сургалтанд хамруулах, төрийн зардлаар суралцуулах асуудлыг холбогдох төрийн захиргааны төв | хувь | Хууль, тогтоомж, норм, дүрэм, олон улсын стандартад нийцсэн байна | ШУТИС, МУИС, ХААИС, ҮТИС гэсэн сургуулиудад геодези, зураг зүйн дээд мэргэжлийн боловсон хүчнийг бэлдэж байна. Эдгээр сургуулиудад нийтдээ 3 доктор, дэд профессор, 4 доктор, 6 докторант, 14 магистр, гол гол хичээлүүдэд цагийн багш /10/ нар багшилж байна ² . Үүнээс сургуулиар нь үзүүлбэл: доктор(Ph.D), дэд профессор – ШУТИС, ХААИС, ҮТИС-д тус бүр 1; | 30 | 60 | БХБЯ, ГЗБГЗЗГ | БХБЯ, БСШУСЯ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |

| | | | | | | | | | |
|----|---|--|---------|---|--|--|--|---------------|---|
| | | байгууллагууд-тай хамтран хэрэгжүүлнэ. | | | доктор(Ph.D)–ШУТИС-1, МУИС-2, ХААИС-1; докторант - МУИС-6; магистр - ШУТИС-6, МУИС-1, ХААИС-2, УТИС-5 тус тус байна. | | | | |
| | | 3.5.2. Гадаад орнуудад геодези, зураг зүйн салбарын боловсон хүчнийг бакалавр, магистр, докторантад суралцуулна. | Оюу-тан | Хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна | Салбарын хэмжээнд 11 доктор, гадаадад хамгаалсан 10, дотоодод хамгаалсан 50 гаруй магистр, давхардсан тоогоор орчим бакалавр байна. | 5 бакалавр, 2 магистр, 1 докторант. | 5 бакалавр, 2 магистр, 1 докторант. | БХБЯ, ГЗБГЗЗГ | БХБЯ, БСШУСЯ, ГЗБГЗЗГ, ГФЗЗХ |
